



СОЁЛЫН ЯАМ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Хамрагдсан байгууллага: Дорноговь аймгийн Соёл, урлагийн газар
Шалгалтын тайлангийн код: ХШҮДАГ-2024/ХШҮ/ДА/13

Аудитын дүгнэлт:

Дорноговь аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын дүнгээр байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг “Сайжруулах шаардлагатай”, санхүүгийн үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэв.

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР1

1.ТАНИЛЦУУЛГА.....2

1.1. Байгууллагын тухай.....2

2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ3

2.1. Зорилго:3

2.2. Хамрах хүрээ, хязгаарлалт3

2.3. Хяналт шалгалтын арга, аргачлал.....3

2.4. Өмнөх шалгалтын талаар4

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ.....4

3.1. Засаглалын удирдлагын талаар4

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар4

3.3. Дотоод хяналтын талаар5

4. Санхүүгийн үйл АЖИЛЛАГААНЫ талаар5

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ7

6. ЗӨВЛӨМЖ7

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ДА	Дотоод аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

1. ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ын 7.2, 7.3, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Дотоод аудитын хорооны 2024 оны төлөвлөгөөг тус тус үндэслэн Соёлын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх удирдамжийн дагуу 04 дүгээр дугаар сарын 22-ны өдөр ХШҮДАГ-ын дарга Д.Түмэндэмбэрэл ахлан, шинжээч Ц.Алтанхуяг, мэргэжилтэн П.Оюунтуяа нар хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

1.1. Байгууллагын тухай

Засгийн газрын 2021 оны 168 дүгээр тогтоолын дагуу Дорноговь аймгийн Засаг даргын 2021 оны А/424 дүгээр захирамжаар Соёлын хэлтсийг тус аймагт анх байгуулсан байна. Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоол, Соёлын сайдын 2022 оны 04 дүгээр тушаалын дагуу Говь сүмбэр аймгийн Засаг даргын А/655 дугаар захирамжаар Соёл, урлагийн газрыг 11 орон тоотойгоор шинэчлэн байгуулсан.

Байгууллагын регистрийн дугаар 3324486, үндсэн үйл ажиллагааны 1000-600-34003 нэмэлт санхүүжилтийн 1000-600-34401 тоот харилцах данснуудаар санхүүгийн төлбөр тооцоог хийж байна.

Дорноговь аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Б/52 дугаар захирамжаар М.Ганжаргалыг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилж, 2022 оны 03 дугаар сарын 21-ны Б/06 дугаар захирамжаар чөлөөлсөн байна. Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга У.Ганбаатарыг Соёлын сайдын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар Соёл, урлагийн газрын даргаар томилсон байна.

Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Б/05 дугаар тушаалаар Ц.Соёлч мааг нягтлан бодогчоор томилж, газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Б/17 дугаар тушаалаар жирэмсний болон амаржсаны амралт олгож ажлаас түр чөлөөлсөн байна. Байгууллагын даргын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Б/20 дугаар тушаалаар Э.Батсүрэнг нягтлан бодогчоор томилсон байна.

Аудитын хамрах хугацаанд дээрх шийдвэрүүдийн дагуу нэгдүгээр гарын үсгийг У.Ганбаатар одоог хүртэл, хоёрдугаар гарын үсгийг Ц.Соёлчмаа, Э.Батсүрэн нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулж байна.

Тус байгууллага нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан.

Бүтэц зохион байгуулалт

Соёлын сайдын 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Аймгийн Соёл, урлагийн газар”-ыг 2 хэлтэс, орон тооны дээд хязгаарыг 11 байхаар тогтоосон. Сангийн яамны баталсан 2024 оны төсвөөр үйлчилгээний ажилтны 1 орон тоо нэмэгдэж, 12 орон тоотой ажиллаж байна.

Засаглах удирдлага: Байгууллагын дүрмийн 1.6-д газар нь орон тооны бус мэргэжлийн зөвлөлтэй байж болох тухай заалтын дагуу даргын дэргэд 5 зөвлөл ажиллаж байна. Үүнд:

2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/05 тушаалаар “Баримт бичиг нягтлан шалгах комисс” 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/06 дугаар тушаалаар “Залуучуудын хөгжлийн зөвлөл”, 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/26 дугаар тушаалаар “Эцэг эхийн зөвлөл, 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/45 дугаар тушаалаар “Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл”, 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/02 дугаар тушаалаар “Ёс зүйн зөвлөл” тус тус байгуулагдсан байна.

Гүйцэтгэх удирдлага: Захиргаа удирдлагын хэлтэс-1, Соёл урлагийн хэлтэс-1, нийт - 12 албан хаагчийн орон тоотой.

2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Зорилго:

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийн дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

2.2. Хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2023 оны үйл ажиллагаа (засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, төсөв, санхүүгийн бүртгэл тооцоо, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр)-ны үр дүнгийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг гүйцэтгэсэн.

Хязгаарлалт: Говь сүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүгийн аудит хийж “Өөрчлөлтгүй дүгнэлт” өгсөн тул уг тайлангийн хамарсан хүрээгээр энэхүү дотоод аудитыг хязгаарлаж, итгэл хүлээлгэсэн болно.

2.3. Хяналт шалгалтын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болго. Үүнд:

- ✓ Төрийн албаны тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

2.4. Өмнөх шалгалтын талаар

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар санхүүгийн аудит хийж “Өөрчлөлтгүй” гэсэн дүгнэлт өгсөн. Аудитын дүнгээр дараах алдаа, зөрчил илэрсэн тул 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн байна. Үүнд:

- Үр дүнгийн урамшууллыг холбогдох журмын дагуу олгох.
- Таван сая төгрөгөөс дээш орлогын 4, зарлагын 17 гүйлгээг байршуулаагүй тул Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай албан шаардлага.

Санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 234 дүгээр албан бичгээр Төрийн аудитын байгууллагад гаргаж тайлагнасан.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянахад 80 хувийн биелэлттэй гэж дүгнэв. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэх талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалттай бус байна.

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар санхүүгийн аудит хийж “Өөрчлөлтгүй” гэсэн дүгнэлтийг өгсөн. Аудитын дүнгээр 7,346.2 мянган төгрөгийн 5 алдааг шалгалтын явцад залруулсан. Мөн дараах алдаа, зөрчлийг арилгуулах тухай 2 албан шаардлага тогтоосон байна. Үүнд:

- Тайлант хугацаанд 206.3 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг цалингийн зардлаас төлсөн.
- Хагас жилийн санхүүгийн тайланд тусгасан 6,649.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллого зохион байгуулах тушаал шийдвэр гаргаагүй ба 12,030.9 мянган төгрөгийн бараа материал, 108,806.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулсан баримтын бүрдэл нь шаардлага хангахгүй байна.

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ

3.1. Засаглалын удирдлагын талаар

Хөдөлмөрийн дотоод журмын талаар:

Байгууллагын даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/02 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан байна.

Тушаал шийдвэрийн талаар:

Тус байгууллага нь 2023 оны үндсэн үйл ажиллагааны чиглэлээр “А” индексийн 47, боловсон хүчний чиглэлээр “Б” индексийн 19, нийт 66 тушаал төлөвлөж гаргасан байна.

Байгууллагын засаглалын талаар ажлын баримт АБ1002-оор ерөнхий 3 асуултын хүрээнд 7 дэд асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 12 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

3.3. Дотоод хяналтын талаар

Дотоод хяналтын тухайд байгууллагын үндсэн үйл ажиллагаа, харьяа байгууллагуудад төлөвлөгөөний дагуу дотоод хяналт хийж тайлагнасан, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын үйл явцын талаар ажлын баримт АБ1004-өөр 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 4 чиглэлийн 13 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Давтамжтай буюу 2-р түвшин”-нд байна.

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 302,804.9 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 2023 онд улсын төсвөөс 302,804.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар харуулав.

Байгууллагын 2023 оны батлагдсан төсөв, гүйцэтгэлийн дүн:

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү + -	Хувь
71702	Соёл урлаг	302,804.9	286,685.2	16,119.7	94.7
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	297,904.9	281,795.6	16,109.3	94.6
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл	234,530.4	226,992.4	7,538.0	96.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх зардал	29,316.3	28,066.9	1,249.4	95.7
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	11,496.8	5,489.9	6,006.9	47.8
2104	Хангамж, бараа материалын зардал	5,194.0	6,344.5	(1,150.5)	122.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000.0	5,142.4	(142.4)	102.8
2107	Томилолт, зочны зардал	2,000.0	2,956.2	(956.2)	147.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	9,530.0	6,425.3	3,104.7	67.4
2109	Бараа үйлчилгээ бусад	837.4	378.1	459.3	45.2
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,900.0	4,889.5	10.5	99.8
2132	Нэг удаагийн тэтгэмж	4,900.0	4,889.5	10.5	99.8

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,212.1 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	7,584.4	12,031.0	4,446.6
Үндсэн хөрөнгө	86,294.0	86,059.5	(234.5)
Нийт хөрөнгө	93,878.4	98,090.5	4,212.1
Богино хугацаат өр төлбөр	-	2,131.3	2,131.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	93,878.4	95,959.2	2,080.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	93,878.4	98,090.5	4,212.1

Бараа материалын дансны үлдэгдэл 4,446.6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 4,179.6 мянган төгрөг, бичиг хэргийн материал 555.9 мянган төгрөгөөр тус тус өсөж, түлш шатахуун, бусад хангамжийн бараа материал 289.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 86,059.5 мянган төгрөг болж өмнөх оноос 234.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,131.3 мянган төгрөг болсон нь түлш халаалтын зардлын өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 95,959.2 мянган төгрөг болж, 2,080.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дорноговь аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын дүнгээр байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг “Сайжруулах шаардлагатай”, санхүүгийн үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэв.

Аудитаар илэрсэн алдаа дутагдлыг залруулах, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг цаглаварт хугацааны дотор Соёлын яамны ХШҮДАГ-т албан бичгээр ирүүлэхийг мэдэгдье.

6. ЗӨВЛӨМЖ

Төсвийн шууд захирагч, дарга У.Ганбаатар танаа		Хугацаа
Зөвлөмж 1.	Шийдвэр гаргах, зорилго, зорилтыг тодорхойлох, урамшуулах, хариуцлага тооцоход эрсдэлийг харгалзан үздэг байх, эрсдэлийн удирдлагын төлөвшлийн түвшнийг ахиулах;	2024 оны 06-р сарын 25-ны дотор
Зөвлөмж 2	Төсвийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр, төсөвт эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх, орон нутгийн соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	
Нягтлан бодогч Э.Батсүрэн танд		
Зөвлөмж 3.	Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн тухай хуулийн 70, 71, 72 дугаар зүйлийг баримтлан хуульд заасан хугацаанд, үнэн зөв, чанартай явуулж, тооллогын бүртгэлийг эд хариуцагч бүрээр актаар баталгаажуулж ажиллах.	2024 оны 06-р сарын 25-ны дотор
Зөвлөмж 4.	Харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актыг үнэн зөв хийх, зардлын нэхэмжлэлийн дагуу өглөгийн бүртгэл хөтөлж байх;	
Зөвлөмж 5.	Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх;	

СОЁЛЫН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

---oOo---